

Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийлэл тооцох аргачлал

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг тооцоход энэхүү аргачлалыг баримтална.

Хоёр.Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг
тооцоход ашиглах мэдээлэл

2.1. Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцоход дараах мэдээллийг ашиглана. Үүнд:

2.1.1. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй даатгуулагч, тэтгэвэр авагчид /төрсөн он, тэтгэвэр авсан он/-ийн мэдээлэл.

$$A = \begin{pmatrix} A_{11} & \cdots & A_{1m} \\ \vdots & \ddots & \vdots \\ A_{n1} & \cdots & A_{nm} \end{pmatrix}$$

Тайлбар:

n-нас /тухайн жилд эрэгтэй-55, эмэгтэй-50 наснаас дээш тэтгэвэр
авагчид/

m-он /сүүлийн 10 жил/

2.1.2. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нас барагчид /төрсөн он, нас барсан он/-ийн мэдээлэл.

$$B = \begin{pmatrix} B_{11} & \cdots & B_{1m} \\ \vdots & \ddots & \vdots \\ B_{n1} & \cdots & B_{nm} \end{pmatrix}$$

Тайлбар:

n-нас /тухайн жилд эрэгтэй-55, эмэгтэй-50 наснаас дээших тэтгэвэр
авагчид/

m-нас барсан он /сүүлийн 10 жил/

2.1.3. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй даатгуулагч, тэтгэвэр авагчид /тоо, насны ангиллаар/-ийн мэдээлэл.

$$E = \begin{pmatrix} E_1 \\ \cdots \\ E_n \end{pmatrix}$$

Тайлбар:

n - нас /тухайн жилд эрэгтэй-55, эмэгтэй-50/

Гурав. Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл
тооцоолох аргачлал

3.1. Аргачлалын 2.1-д заасан мэдээллийг ашиглан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг дараах байдлаар тооцоолно. Үүнд:

3.1.1. Аргачлалын 2.2.1, 2.2.2-д заасан мэдээллээс даатгуулагч, тэтгэвэр авагчидын нас барж байгаа тархалтын харьцааг дараах байдлаар гаргана.

$$C = \begin{pmatrix} \frac{B_{11}}{A_{11}} & \dots & \frac{B_{1m}}{A_{1m}} \\ \vdots & \ddots & \vdots \\ \frac{B_{n1}}{A_{n1}} & \dots & \frac{B_{nm}}{A_{nm}} \end{pmatrix}$$

Тайлбар:

-Тэтгэвэр авагчийн нас тус бүрээр сүүлийн 10 жилийн нас баралтын тархалтыг харьцааг харуулна.

3.1.2. Аргачлалын 3.1.1-д тооцсон үр дүнгээс сүүлийн 10 жилд даатгуулагч, тэтгэвэр авагчид хэдэн насанд ямар харьцаатай нас барж байгааг харьцааг дараах байдлаар тооцоолон гаргана.

$$D = \begin{pmatrix} \frac{C_{11} + \dots + C_{1m}}{m} \\ \dots \\ \frac{C_{n1} + \dots + C_{nm}}{m} \end{pmatrix}$$

Тайлбар:

-Сүүлийн 10 жилд нас тус бүр дээр арифметик дунджаар ямар харьцаатай нас барж байгааг харуулна.

3.1.3. Тухайн онд нас барах тэтгэвэр авагчийн тоог дараах байдлаар гаргана.

$$H_{1+l} = \left(\begin{pmatrix} E_{1+l} \\ \dots \\ E_{n+l} \end{pmatrix} - \sum_0^l H_l \right) * D$$

Тайлбар:

$$H_0 = 0$$

$$L-(0, \infty)$$

(∞ - энэ нь хэдэн жилийн таамаг гаргах гэж байгаагаас хамааран хязгаарыг тогтооно.)

3.1.4. Он тус бүрт нас барж байгаа иргэдийн дундаж наслалтын тооцооллыг дараах байдлаар гаргана.

$$K_{1+l} = \frac{\sum_0^n \text{Нас} * H_{1+l}}{\sum_0^n H_n}$$

Тайлбар:

Он тус бүр дээр нас барах тэтгэвэр авагчдын дундаж нас

Дөрөв. Тооцоолол хянах

4.1. Энэхүү аргачлалыг ашиглан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцоолсон үр дүнг Үндэсний статистикийн хороо хянана.

---oOo---